


САЛБАР ЗАМ АРЧЛАЛТЫН ГЭРЭЭ



№ 05/02/064
10/2022

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ /цаашид гэрээ гэх/- г,
Нэг талаас, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-ыг/ 10/61 тоот итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлж, Замын 2-р ангийн дарга Д.Алтангэрэл /цаашид "Ажил гүйцэтгэгч" гэнэ/.

Нэгөө талаас, Улсын бүртгэлийн 9012001030, Регистрийн 6021646 дугаартай "Амгалан дулааны станц" ТӨХК түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай Ш.Баянмөнх /цаашид "Салбар зам эзэмшигч" гэнэ/ нар хүсэл, зориг, ашиг сонирхлоо бүрэн илэрхийлж Монгол улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй МУ-ын стандарт, дүрэм, журмыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд гэрээний бүх зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн танилцаж хүлээн зөвшөөрөгдсөн байх, хүсэл зоригоо бүрэн илэрхийлсэн байх зарчимд тулгуурлагдсан болохыг хоёр тал харилцан хүлээн зөвшөөрөв.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Гэрээний зорилго:

1.1.1. Ажил гүйцэтгэгч нь салбар зам эзэмшигчийн зам, гаралт, суман шилжүүлэг зэргийг бүхэлд нь "Техник ашиглалтын журам" / ТАЖ/, технологийн горимын дагуу арчлалт үйлчилгээ хийхээс гадна хяналт тавьж гарсан гэмтлүүдийг засварлах, салбар зам эзэмшигч нь түүнд тохирсон ажлын хөлсийг телөх болон талуудын хооронд үүсэх бусад харилцааг энэ гэрээгээр зохицуулна.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 2.1. Салбар замын дэлгэмэл урт – 500 метр болно.
- 2.2. Салбар зам нь "Амгалан дулааны станц" ТӨХК -ийн балансын зам болно.
- 2.3. Салбар зам нь 2 ширхэг /комплект/ суман шилжүүлэг, 2 хамгаалалтгүй гаралт, 1 хамгаалалттай гаралтай болно.
- 2.4 Замын нийт урт нь суман шилжүүлгийн хамт 500 метр болно.
- 2.5 Энэхүү гэрээ нь 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд үйлчилнэ.

ГУРАВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. 0,5 км салбар зам, 2 ширхэг /комплект/ суман шилжүүлэг, 2 хамгаалалтгүй гаралт, 1 хамгаалалттай гаралтыг бүхэлд нь ТАЖ, технологийн горимын дагуу тогтмол үзлэг хийж, байнгын арчлалт үйлчилгээ хийхээс гадна хяналт тавьж, түүнд илэрсэн гэмтлүүдийг цаг тухайд нь засварлаж байна.
- 3.2. Салбар замаар хөдлөх бүрэлдэхүүнийг тогтоосон хурдаар явуулахад замыг бэлэн байлгана.

Ажил гүйцэтгэгчийг төлөөлж

Салбар зам эзэмшигчийг /ашиглаж/ төлөөлж

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

- 3.3. Гэрээний үйлчлэх хугацаанд салбар замд зам арчлалтын буруугаас дутагдал, гологдол гарвал засч өгнэ.
- 3.4. Салбар зам эзэмшигчийн зам, суман шилжүүлэг, гармын цэвэрлэгээг бүрэн хариуцна.
- 3.5. Салбар зам эзэмшигч нь гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байх, арчлалт, засвар үйлчилгээ хийлгэх боломжоор хангахгүй байх, зам бохирдуулах, салбар зам дээр ачааг оворгүй ачих, буулгах зэргээр галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд саад учруулах нехцэл байдал бий болгох, ажил гүйцэтгэгчийн анхааруулгыг хүлээж авахгүй байх тохиолдолд гэрээг дангаар цуцлах, салбар замыг хаах хүртэл арга хэмжээ авна.
- 3.6. Салбар зам эзэмшигчийн эзэмшлийн замын байршилтай холбоотой мэдээллийн нууцыг чанд сахина.
- 3.7. Ажил гүйцэтгэгч нь төмөр замын тээврийн аюулгүй байдал, галт тэрэгний хөдөлгөөний хэвийн ажиллагааг хангах үүднээс салбар замыг суман, шилжүүлэг, гармын хамт бүхэлд нь арчлах ба зам, суман шилжүүлгийг салгаж арчлахаас татгалзах эрхтэй.

ДӨРӨВ. САЛБАР ЗАМ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Төмөр замын объектын гэрчилгээжүүлэлтэд хамрагдаж эрх бүхий байгууллагаас гэрчилгээ авсан байна.
- 4.2. Салбар зам дээр ачаа ачиж буулгахдаа ТАЖ-д заасан техникийн шаардлага, норм, норматив болон барилга байгууламжийн овор хэмжээг "С" шаардлагад тохируулна.
- 4.3. Төмөр замын барилга байгууламжийн овор хэмжээний дотор ямар нэгэн барилга байгууламж барих, шинээр гарам гаргахгүй байх үүргийг хүлээх ба энэ шаардлагыг хангагүйгээс гарах хариуцлагыг хүлээнэ.
- 4.4. Зам, сум, гармын орчинд ачааны буулгалт ба ачилтаас бий болсон хогшороо, цаас, цас мөс, зэргийг тогтмол цэвэрлэж цэвэр байлгах, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд нелөөлж болох эд зүйлс байлгахгүй, зам, сум, гармын үзлэг шалгалт, засвар үйлчилгээ хийхэд саад болохгүй нехцэлийг хангах үүргийг хүлээнэ.
- 4.5. Салбар зам эзэмшигч нь гарам ашиглах тохиолдолд "Төмөр замын гарам ашиглах журам"-ын дагуу хэвийн байлгах, шаардлагатай тохиолдолд өөрсдийн хүчээр сэргээн засварлаж, зориулалтын стандарт тэмдгээр тоноглосон байна.
- 4.6. Төмөр замын барилга байгууламжийн овор хэмжээн дотор ямар нэгэн барилга байгууламж шинээр барих, шинэ гарам гаргахгүй ба шаардлагатай тохиолдолд замын ангид урьдчилан мэдэгдэж төрийн эрх бүхий байгууллагаас холбогдох зөвшөөрлийг авч зураг төслийг урьдчилан тохирно.
- 4.7. Салбар зам эзэмшигч нь төмөр замтай кабель шугам төхөөрөмж огтлолцуулах бол замын ангид урьдчилан мэдэгдэж эрх бүхий байгууллагаас холбогдох зөвшөөрлийг авч ажиллах цагийн хуваарь, сэлгээний хөдөлгөөнийг зогсоох эсэх талаар нарийн тохирч, төлөөлөгч байлцуулж ажлыг гүйцэтгэнэ.
- 4.8. Салбар зам эзэмшигч нь төмөр зам доогуур байрлах байгууламж, өөрийн эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн кабель шугам, холбоо, цахилгааны утасны гүн байршилыг тодорхойлж, тэмдэг тэмдэглэгээг төмөр замд мөрддөг стандартын дагуу оврын зайн ханган байршуулж ажилчдыг хэвийн, аюулгүй ажиллах нехцөлөөр хангана.

ТАВ. АЖЛЫН ХӨЛС БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 5.1. Зам, сум, гармын байнгын арчилгааны хөлсийг Замын албаны даргын 2016 оны 12 сарын 02-ны өдрийн 34 тоот тушаал, Замын даргын 2021 оны A-779 тушаалаар батлагдсан тарифыг үндэслэн дараах байдлаар тооцно. Үүнд:

Ажил гүйцэтгэгчийг төлөөлж
Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Салбар зам эзэмшигчийг /ашиглагч/ төлөөлж
.....

№	Замын байгууламж	Нэгж	Техникийн үзүүлэлт	Үнэлгээ	Нийт дүн
1	Салаа зам	км	0.500	21,143,740	10,571,870
2	Суман шилжүүлэг	ш	2	3,136,780	6,273,560
3	Хамгаалалттай гарам	ш	1	156,641,997	156,641,997
4	Хамгаалалтгүй гарам	ш	2	924,600	1,849,200
5	Үндсэн хөрөнгийн элэгдэл	км			
6	Бага үнэтэй багажны элэгдэл	км			
7	Бүгд	ЖИЛД			175,336,627
8		УЛИРАЛД			43,834,157
9		САРД			14,611,386

- 5.2. Зам арчлалтын хөлсийг ажил гүйцэтгэгчийн нэхэмжлэхийн дагуу улирал эхлэхийн өмнөх сарын 30-ны өдрийн дотор төлнө. Хугацаанд нь төлбөрөө төлөөгүй тохиолдолд улирлын эхэнд замыг хаах хүртэл арга хэмжээ авна.
- 5.3. Салбар зам эзэмшигч зам арчлалтын болон засварын ажлын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй үнийн дунгийн 0,5 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.
- 5.4. Салбар зам эзэмшигч нь зам арчлалтын төлбөрийг 1 сараас дээш хугацаагаар төлөөгүй бол зам арчлалтыг зогсоох ба үүнтэй холбогдуулан арчилгаагүй замд хөдлөх бүрэлдэхүүн явуулахгүй байх тухай шаардлагыг хургуулнэ.
- 5.5 Ажил үйлчилгээний тарифт өөрчлөлт орсон тохиолдолд “Төмөр замын тээврийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасны дагуу салбар зам эзэмшигчид 10 доoshгүй хоногийн өмнө мэдэгдэх ба өөрчлөгдсөн өдрөөс эхлэн шинэчилсэн тарифыг мөрдөнө.
- 5.6. Тухайн салбар зам дээр их засвар болон өргөлтийн засварын ажил хийгдэх, байгалийн гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас объектод эвдрэл гэмтэл гарвал талуудын эрх бүхий төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын хэсэг хамтран шалгаж, гэмтлийн акт үйлдэнэ. Тогтоосон гэмтлийн актыг үндэслэн УБТЗ-д мөрддөг үнэлгээг баримтлан ажил гүйцэтгэгч засварын ажлыг гүйцэтгэх ба ажил гүйцэтгэсэн актын дагуу салбар зам эзэмшигч ажлын 10 хоногийн дотор төлбөрийг төлнө.
- 5.7. Зам арчлалтын төлбөрийн хуваарийг хавсралт 1-д заасан болно.
- 5.8. Энэхүү гэрээний 7.1-д заасны дагуу гэрээг цуцалсан нь Салбар зам эзэмшигчийг зам арчлалтын гэрээний төлөх ёстой төлбөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Салбар зам эзэмшигч, ажил гүйцэтгэгч хоёрын аль нэгний буруугаар галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд саад болох гологдол, зөрчил гарвал түүний хариуцлага ба эд материалын хохирлыг буруутай тал нь хүлээнэ. Хагас ба бүтэн жилд талууд Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хэрхэн хангасан тухай протокол бичиж гэрээг дүгнэнэ.
- 6.2. Энэ гэрээний 3 болон 4 дүгээр зүйлд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс талуудад болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг буруутай тал хариуцлагыг хүлээж хохирлыг барагдуулна.
- 6.3. Шаардлагатай тохиолдолд Төмөр замын тээврийн улсын байцаагч, УБТЗ-ын хяналтын байцаагч нар хөдөлгөөний аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгааг хууль, дүрэм, журмын дагуу холбогдох төлөөллийг байлцуулан шалгаж, шаардлага, акт, дүгнэлт, зөвлөмжийг өгнө.

Ажил гүйцэтгэгчийг төлөөлж

Салбар зам эзэмшигчийг /ашиглагч/ төлөөлж

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

7.1. Гэрээ цуцлах

- 7.1.1. Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцлах бол талууд бие биедээ ажлын 5 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.
- 7.1.2. Дараах тохиолдолд гэрээг ажил гүйцэтгэгч өөрийн санаачилгаар цуцална. Үүнд:
а/энэ гэрээний 4.3-т заасан шаардлага, нөхцөлийг хангаагүй.
б/ төлбөрөө хугацаандаа төлөөгүй.

7.2. Гэрээний хугацаа болон гэрээний хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулах

- 7.2.1. Талууд гэрээ болон гэрээний хугацаанд тухайн онд нэмэлт өөрчлөлт оруулах бол саналаа негеэ талдаа харилцан тохирсноос бусад тохиолдолд ажлын 5 хоногийн өмнө бичгээр ирүүлнэ.
- 7.2.2. Нэмэлт өөрчлөлтийн хугацаа сунгалтыг үндсэн гэрээнд шууд санал гаргагч талын санал болгосон хугацаагаар сунган нэмж бичих ба мөн хугацаагаар сунгасанд тооцно.
- 7.2.4 Энэхүү нэмэлт өөрчлөлт нь энэ гэрээний салшгүй хэсэг болно.

7.3. Баталгаа

- 7.3.1. Талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан мөнгөн буюу мөнгөн бус хэлбэрээр шагнал, шан харамж, урамшуулал зэрэг энэ гэрээнд тусгагдаагүй аливаа төлбөрийг харилцан төлөөгүй болно.
- 7.3.2. Талууд энэ гэрээнд дурдсан өөрийн эрхийг негеэ талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэн өгч болохгүй.

7.4 Маргаан шийдвэрлэх

- 7.4.1. Гэрээг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд байгуулсан бөгөөд түүнд заасны дагуу ойлгож, тайлбарлагдана.
- 7.4.2. Гэрээнд заагаагүй бусад асуудлыг Монгол улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 7.4.3. Гэрээний хугацаанд үүсэх маргаантай асуудлыг хоёр тал харилцан эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Тохиролцоонд эс хүрсэн тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.5. Нууцыг хадгалах

- 7.5.1. Талууд бие биедээ өгсөн аливаа нэг мэдээллийн нууцыг гэрээний хугацаа дууссан эсэхээс үл хамааран чанд хадгална.
- 7.5.2. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр бүхий л бичиг баримт, тоо мэдээлэл, олж авсан болон цуглуулсан мэдээллээ ямар нэг байдлаар гэрээний үргийг биелүүлэхээс бусад тохиолдолд олшруулах, нийтэд тараах, нийтлэх, задруулах эрхгүй.
- 7.5.3. Нууц хадгалах үүргээ биелүүлээгүйгээс талуудын хэн алинд ямар нэг хохирол учирсан тохиолдолд хохирлыг үл маргах журмаар төлж барагдуулна

7.6. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

- 7.6.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг, дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт зэрэг нь энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдал бий болохыг ойлгоно.
- 7.6.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол негеэ талдаа ажлын таван хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно. Гэнэтийн болон давагдашгүй

Ажил гүйцэтгэгчийг төлөөлж

Салбар зам эзэмшигчийг /ашиглагч/ төлөөлж

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болохыг хориглоно. Энэ шаардлагааг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

хүчин зүйл хуанлийн 30-аас дээш хоногийн хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцэх замаар шийдвэрлэнэ.

- 7.6.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нэхцэл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд давагдашгүй хүчин зүйлийн нэхцэл байдлаас шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд харилцан чөлөөлөгднө.

7.7 Гэрээ хүчин төгөлдөр болох

- 7.7.1. Энэхүү гэрээ нь Монгол хэл дээр 2 /хоёр/ эх хувь байх бөгөөд хоёр талын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, дугаар авч, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 7.7.2. Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захицууд нь бичгийн хэлбэрээр байх бөгөөд доорх хаягаар хүргэсэн үед тухайн баримтыг хүлээн авсанд тооцно.
- 7.7.3. Энэхүү гэрээний салшгүй хэсэг болох дор дурдсан хавсралт болон бусад бичиг баримтууд дутуу тохиолдолд гэрээний бүрдэл хэсэг хангагдаагүй гэж үзнэ. Үүнд:
- Салбар зам өмчлөгчийн гэрчилгээ, эсхүл, түрээсийн гэрээ /замыг түрээсээр эзэмшиж байгаа тохиолдолд/-ний хуулбар, албан бичиг
 - Салбар замын гэрчилгээжилтийн хуулбар
 - Салбар замын дэлгэмэл болон огтлолын зураг
 - Техникийн байдлыг тогтоосон акт
 - Газар эзэмшигчийн гэрчилгээний хуулбар
 - Салбар зам өмчлөгч, эзэмшигч байгууллагын захирлын иргэний үнэмлэхний хуулбар
 - Бусад шаардлагатай баримт /гэрээ байгуулах үед Замын анги шаардсан тохиолдолд /
- 7.7.4. Гэрээ болон түүний хэрэгжилттэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, хүсэлтийг талууд дараах албан ёсны хаягаар хүргүүлнэ. Үүнд:

Салбар зам эзэмшигч:

Хаяг: Баянзүрх дүүрэг, 8-р хороо. УС-15-ын 1-1

Утас: 99047300, 99662289, 99026048

Э-майл: battsooj.b2@gmail.com

Холбогдох /харьцах/ албан тушаалтан. Ахлах инженер Б.Батцож

Ажил гүйцэтгэгч:

Хаяг: Баянгол дүүрэг. Сөүлийн гудамж.

Утас: 21244520, 21244537, 86113276, 99043276

Э-майл: usgooo22@yahoo.com,

Холбогдох /харьцах/ албан тушаалтан: Салбар зам хариуцсан инженер Н.Өсөхтуяа

Гэрээ хариуцагч: Б.Батчулуун 99016995, chuka_pch3@yahoo.com

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН
БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ТӨЛӨӨЛЖ:



Дарга

Д.Алтангэрэл

САЛБАР ЗАМ ЭЗЭМШИГЧИЙГ

"Амгалан дулааны станц" ТӨХК –ийн
гүйцэтгэх

Захирал



Ш.Баянмөнх

Ажил гүйцэтгэгчийг төлөөлж

Салбар зам эзэмшигчийг /ашиглагч/ төлөөлж

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул вээр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

ПЧФ

ПЧИ

ПЧИд

Н.Эрдэнэбаяр

Н.Өсөхтуяа

Б.Батчулуун

Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий
инженер

Ч. Цогтсайхан

СЭЗХ-ийн дарга бөгөөд ерөнхий нягтлан
бодогчийн ажил үүргийг түр орлон
гүйцэтгэгч

О.Удвал

Түлш дамжуулах цехийн дарга

Д.Түвшинзаяа

Ахлах инженер

Б.Батсоож

Хянасан:

Хуулийн мэргэжилтэн

Г.Саруул

Зөвшөөрсөн:

НН

НЮ

П

САЛБАР ЗАМ АРЧЛАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

№	Агуулга	Төлбөр шилжүүлэх хугацаа	Төлбөрийн нэгж	Улиралд төлөх дүн
1	2022 оны 1-р улирлын төлбөр	Тухайн сарын 05-ны дотор	төгрөг	43,834,157
2	2022 оны 2-р улирлын төлбөр	03 дугаар сарын 30-ны дотор	төгрөг	43,834,157
3	2022 оны 3-р улирлын төлбөр	06 дугаар сарын 30-ны дотор	төгрөг	43,834,157
4	2022 оны 4-р улирлын төлбөр	09 дүгээр сарын 30-ны дотор	төгрөг	43,834,156
	Дүн		төгрөг	175,336,627

Хүлээн зөвшөөрсөн:

АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ТӨЛӨӨЛЖ:

Дарга



Замын 2-р ангийн

Д.Алтангэрэл

САЛБАР ЗАМ ЭЗЭМШИГЧИЙГ

“Амгалан дулааны станц” ТӨХК –ийн
Гүйцэтгэх захирал

Ш.Баянмөнх